



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/04

Өвт

Гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн хуучин хогийн цэгийг ландшафлийн аргаар дарж булшлах ажлыг шууд гэрээ байгуулах аргаар "Бат-Өлзий сумын Тохижилт үйлчилгээний компани"-аар гүйцэтгүүлсүгэй.
2. "Тохижилт үйлчилгээний компани"-тай гэрээ байгуулж, хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Янжиндулам)-д даалгасгай.
3. Сумын төвийн хуучин хогийн цэгийг ландшафлийн аргаар дарж булшлахад шаардагдах 9960000 (есөн сая есөн зуун жаран мянган) төгрөгийг гэрээний дагуу санхүүжүүлэхийг Санхүүгийн албаны нягтлан бодогч (Б.Мажигдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

М.ЖАМЪЯНШАРАВ



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

051010127